



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/465


Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дах хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хооронд 2017 оны 6 дугаар сард байгуулсан "Монгол Улсын Зүрх судасны үндэсний төв ба зүрх судасны тусламж, үйлчилгээг уялдуулан сайжруулах нь МОН/006" төслийн гэрээ, Улсын гуравдугаар төв эмнэлэг болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Ча Бунданг эрүүл мэндийн төв хооронд 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан "Зөвлөх үйлчилгээний гэрээ"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД




Д.САРАНГЭРЭЛ

081841

Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 11 сарын 20-ны өдрийн  
дугаар тушаалын хавсралт

А/4165



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

	Овог нэр	Харъяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Пак Хан Ки Park Han Ki	Бүгд Найрамдах Солонгос Улс	Улсын гуравдугаар төв эмнэлэг	ГЭ0002163	Цээжний ба зүрх судасны мэс засал	Эмчлэх	2018.12.08-2018.12.15 /8 хоног/